**МОНГОЛ УЛСЫН**
**ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛ**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Худалдааны гудамж 6/1, Засгийн газрын Y байр,
Утас: 32-76-88, Факс: 32-76-97,
E-mail: Gcouncilcourts@mol.mn

МОНГОЛ УЛСЫН ГАДААД ХЭРГИЙН САЙД Л.ЭРДЭНЭЧУЛУУН ТАНАА

2002.08.30 № 32

танай 04/2945 -ны № -т

Санал дэмжих тухай

Танаас ирүүлсэн олон улсын эрүүгийн шүүхийн шүүгчид Монгол улсаас НҮБ-ын дэргэд суугаа Байнгын төлөөлөгч, Элчин сайд Ж.Энхсайханы нэрийг дэвшүүлэх саналыг судалж үзлээ.

Ж.Энхсайхан нь 1950 оны 9 дүгээр сард Улаанбаатар хотод төрсөн, 52 настай, ам бүл 6, 1974 онд Москва хотын Олон улсын харилцааны дээд сургууль төгссөн. 1979 онд мөн сургуулийн аспирантурт суралцаж хууль зүйн ухааны дэд эрдэмтэн цол хамгаалсан.

Тэрээр 1974-1979 онд БНМАУ-ын ГЯЯ-ны гэрээ эрхийн хэлтэст дэд атташе, атташе, хоёрдугаар нарийн бичгийн дарга, 1979-1986 онд БНМАУ-аас НҮБ-ийн дэргэд суугаа Байнгын төлөөлөгчийн газарт гурав, хоёрдугаар нарийн бичгийн дарга, 1986-1988 онд БНМАУ-ын ГЯЯ-ны Төлөвлөлт, боловсруулалтын болон Гэрээ эрх, түүх архивийн хэлтэст даргын үүрэг гүйцэтгэгч, 1988-1992 онд Монгол улсаас ЗХУ (ОХУ)-д суугаа элчин сайдын яамны элчин зөвлөх, 1992-1993 онд Монгол улсын Ерөнхийлөгчийн хуулийн болон Гадаад бодлогын зөвлөх, 1993-1996 онд Монгол улсын Үндэсний Аюулгүй байдлын Зөвлөлийн нарийн бичгийн дарга, 1996 оноос одоог хүртэл Монгол улсаас НҮБ-ийн дэргэд суугаа Байнгын төлөөлөгчөөр ажиллаж байна. Ж.Энхсайхан нь НҮБ-ийн Ерөнхий ассамблейн чуулганы Хууль зүйн хорооны орлогч дарга(1984), даргын(1998) албан тушаалыг хашиж байсан олон улсын хууль, эрх зүйн өндөр боловсрол, арвин туршлагатай дипломатч юм.

Олон улсын эрүүгийн шүүхийн дүрмийн 36 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн а-д "Шүүгчдийг өөрсдийнх нь холбогдох улсуудын шүүхийн өндөр албан тушаалд томилоход тавигдах шаардлагыг хангасан шударга, хараат бус, өндөр ёс суртахуунтай хүмүүсээс сонгож авна", түүнчлэн мөн зүйлийн 4 дэх хэсгийн а-ийн I-д "Тухайн улсад шүүхийн дээд албан тушаалд томилох нэр дэвшигчийг дэвшүүлэх талаар мөрдөж буй журмын дагуу" болон II-д "Олон улсын шүүхийн бүрэлдхүүнд нэр дэвшүүлэх талаар Олон улсын шүүхийн дүрэмд тусгагдсан журмын дагуу. . ." шүүгчид нэр дэвшүүлнэ гэж заасан байна.

Ж.Энхсайхан нь Монгол улсын үндсэн хуулийн 51 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан Улсын дээд шүүхийн шүүгчээр томилох болон, 65 дугаар зүйлын 2 дахь хэсэгт заасан Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилох болзлуудыг бүрэн хангаж байгаа тул Олон улсын эрүүгийн шүүхийн дүрмийн 36 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасныг ~~үндэслэн Монгол улсын~~ нэрийн өмнөөс Олон улсын эрүүгийн шүүхийн шүүгчийн сонгуульд оролцуулах саналыг бүрэн дэмжиж байна.

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД,
ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН
ДАРГА Ц.НЯМДОРЖ

0502

*__Unofficial translation from Mongolian__*

# General Council of Courts of Mongolia

**30 August, 2002** | **Note No. 32** | **City of Ulaanbaatar**

**To: H.E. L.Erdenechuluun**
**Minister of Foreign Affairs of Mongolia**

**Re.: Response to your note 04/2945 in support of your proposal**

**I have examined your proposal to nominate Ambassador J. Enkhksaikhan, Permanent Representative of Mongolia to the United Nations for election as the judge of the International Criminal Court.**

**J. Enkhsaikhan was born in September 1950 in Ulaanbaatar and is 52 years old. He has a family of 6. In 1974 he graduated Moscow State Institute for International Relations. In 1979 he received his doctor's degree from the same institute.**

**In 1974-79 he worked as assistant attaché, attaché and second secretary in the Treaty and Legal Affairs department of the Ministry of Foreign Affairs (MFA) of Mongolia, in 1979-86 as third, second secretary of the Permanent Mission of Mongolia to the United Nations, in 1986-88 as acting head of the Policy Planning and Treaty and Legal Affairs departments (MFA), in 1988-1992 as Minister Counsellor of the Mongolian Embassy in the USSR/Russian Federation, in 1992-93 as the legal and foreign affairs advisor to the President of Mongolia, in 1993-96 as the Executive Secretary of the National Security Council of Mongolia and since 1996 he is working as the Permanent Representative of Mongolia to the United Nations. J. Enkhsaikhan served as Vice-Chairman (1984) and Chairman (1998) of the Sixth (legal) Committee of the General Assembly of the United Nations and is a diplomat with high international legal education and rich experience.**

**Article 36 (3)(a) of the Statute of the International Criminal Court stipulates that " the judges shall be chosen from among persons of high moral character, impartiality and integrity who possess the qualifications required in their respective States for appointment to the highest judicial offices". Furthermore, paras. (4)(a)(i) and (ii) of that Article stipulate that nomination of candidates for election to the Court ... may be made either "by the procedure of the nomination of candidates for**

**appointment to the highest judicial offices in the State in question" or "by the procedure provided for the nomination of candidates for the International Court of Justice in the Statute of the Court".**

**Since J. Enkhsaikhan fully satisfies the criteria set out in Article 51(3) of the Constitution of Mongolia on the appointment of judges of the Supreme Court and Article 65(2) of the Constitution on the appointment of members of the Constitutional Court, and basing on Article 36(3) of the Statute of the International Criminal Court, I fully support nominating him on behalf of Mongolia for election as the judge of the International Criminal Court.**

**( seal ) Minister of Justice and Home Affairs — Ts. Nyamdorj**
**President of the General Council of Courts**

**МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН**

# ТОГТООЛ

2002 оны 08 дугаар сарын 30-ны өдөр | Дугаар 274 | Улаанбаатар хот

НЭР ДЭВШҮҮЛЭХ ТУХАЙ

Монгол Улсын Үндсэн хуулийн тавин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Шүүхийн тухай хуулийн 24 дүгээр зүйл, Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрмийн 36 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн "а"-д заасныг удирдлага болгон Монгол Улсын Дээд шүүхээс ТОГТООХ нь:

1. Олон улсын эрүүгийн шүүхийн шүүгчид Монгол Улсын иргэн Жаргалсайханы Энхсайханы нэрийг дэвшүүлсүгэй.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ Ч.ГАНБАТ

ТАНХИМЫН ТЭРГҮҮН ШҮҮГЧ Р.ЖАМЪЯНЧОЙЖИЛ

*Unofficial translation from Mongolian*

## The Supreme Court of Mongolia

## RESOLUTION

**30 August, 2002** **No. 274** **City of Ulaanbaatar**

**Re.: NOMINATION OF CANDIDATE**

**Mindful of Article 51(2) of the Constitution of Mongolia, Article 24 of the Law of Mongolia on Courts as well as Article 36 (4)(a) of the Statute of the International Criminal Court, the Supreme Court of Mongolia decides to:**

1. **Nominate Jargalsaikhany Enkhsaikhan, citizen of Mongolia for election as the judge of the International Criminal Court.**

**( seal ) General judge ( signature ) Ch. Ganbat**

**Head judge of the chamber (signature) R. Jamyanchoijil**

# МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦ

2002 оны 08 дугаар сарын 30-ны өдөр

Дугаар 97

Улаанбаатар хот

**МОНГОЛ УЛСЫН ГАДААД ХЭРГИЙН САЙД Л.ЭРДЭНЭЧУЛУУН ТАНАА**

**Нэр дэвшигчийн тухай**

Монгол Улсын нэрийн өмнөөс Олон улсын эрүүгийн шүүхийн шүүгчийн сонгуульд элчин сайд Ж.Энхсайханы нэрийг дэвшүүлэх тухай танай санал болон Ж.Энхсайханы талаар ирүүлсэн материалтай нягтлан танилцлаа.

Монгол Улс иргэнээ Олон улсын эрүүгийн шүүхийн шүүгчид шүүгчээр сонгуулан ажиллуулах нь Монгол Улсаас олон улсын эрүүгийн эрх зүйг мөрдүүлэх, бэхжүүлэх үйлсэд оруулах хувь нэмэр хэмээн үзэж, элчин сайд Ж.Энхсайханы мэргэжил боловсрол, төрийн болон гадаад харилцааны байгууллагад хариуцлагатай алба хашиж олсон ажлын дадлага зэргийг харгалзан Олон улсын эрүүгийн шүүгчид шүүгчээр нэр дэвшүүлэх бүрэн боломжтой гэж үзэж байна.

**ДАРГА** **Н.ЖАНЦАН**

*<u>Unofficial translation from Mongolian</u>*

# Constitutional Court of Mongolia

**30 August, 2002** **No. 97** **City of Ulaanbaatar**

**To: H.E. L. Erdenechuluun**
**Minister of Foreign Affairs of Mongolia**

**Re.: Candidature for nomination**

**I have carefully studied your proposal to nominate on behalf of Mongolia Ambassador J. Enkhsaikhan for election to the judge of the International Criminal Court and examined the materials sent to me concerning J. Enkhsaikhan.**

**Nomination and election of a Mongolian citizen to be the judge of the International Criminal Court would be Mongolia's contribution to the international community's efforts of fuller enforcement of rule of law and strengthening of international criminal justice. Bearing in mind Ambassador J. Enkhsaikhan's educational and professional backgrounds, the rich experience that he has acquired when holding high and important posts in State and foreign affairs, I believe that he is fully qualifies to be nominated for election as the judge of the International Criminal Court.**

**( seal )** **President** **( signature )** **N. Jantsan**